

76



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 3/6

Номгон

**Бичил уурхайгаар ашигт малтмал
олборлох тухай**

Дэлхий нийтийг хамарсан Коронавирус цар тахлын улмаас бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, тэг зогсолт буюу олон удаагийн хөл хорио тогтоосноос шалтгаалан иргэдийн бизнесийн орлого буурч эдийн засаг хүндрэх, ажилгүйдэл нэмэгдэх нөхцөл бүрдсэн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж орон нутаг ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийг ажилтай, орлоготой болгох зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” болон холбогдох хуулийн хүрээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох бүртгэлтэй нөхөрлөлтэй хуулийн хүрээнд гэрээ байгуулан хариуцлагатай бичил уурхайг дэмжиж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд хяналт тавьж, бодлогоор дэмжиж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



1200050